



**“Өлзийт экаунт  
аудит” ХХК**

## **“ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН”**

**“ТАЛХ ЧИХЭР” ХХК  
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31  
-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР  
БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

☎ +976 70130460

☎ +976 99109702, 88117655

📍 Ажлын байрны хаяг: 65  
байр, 01 тоот өргөтгөл,  
6-р хороо, Бумцэндийн  
гудамж, Чингэлтэй  
дүүрэг, Улаанбаатар хот

✉ Auditulziit@gmail.com



Улаанбаатар хот  
2026.04.15

# ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН “ТАЛХ ЧИХЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

### Санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

“Талх чихэр” ХК-ийн (цаашид компани гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тодруулгад аудит хийж гүйцэтгэлээ. Аудитын дүгнэлтийн үндэслэлд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Талх чихэр” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бусаар хуулийн дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан нотолгоо нь бидний гаргасан аудитын хязгаарлалттай дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Бид дараах асуудлыг хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл болгож байна.

Санхүүгийн тайлангийн үлдэгдлийг баталгаажуулах хангалттай нотолгоо олж авахыг стандартаар шаарддаг боловч компани нь авлага өглөгийн дансыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тооцооны дансны сөрөг үлдэгдлийг залруулаагүйн улмаас тооцооны дансны үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухайн хуулийн 20 дугаар 20.2.6.-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалтыг тус тус зөрчсөн үнэн зөв байх, нийцсэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлаас өндөр байгаа тул бид хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлуудыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй. Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан асуудлаас гадна дор дурдсан асуудлыг бид тайландаа мэдээлэхүйц аудитын гол асуудал хэмээн тодорхойлсон. Үүнд:

Татвар болон нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учир бид татварын багц хуулийн хэрэгжилтийг эрх бүхий байгууллага шалгаж

хүү, торгууль, алданги, нөхөн татвар тавигдах эрсдэл байгааг тооцон татварын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

#### **Бидний гүйцэтгэсэн горим, сорил :**

Татварын тооцоолол болон түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого, татварын талаарх засаглах удирдлагын байр суурь үнэлгээг судлах, санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын тооцооллын үнэн зөвийг үнэлэх, татварын цахим системтэй тулган баталгаажуулах горим сорилыг гүйцэтгэсэн.

Бид өөрсдийн үнэлэмж тооцоолол, олж авсан мэдлэг, нотлох баримтыг үндэслэн үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч эрсдэл байсаар байгаа.

#### **Бусад мэдээлэл**

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Хэрэв бид аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээлэлд хийсэн өөрсдийн ажилд үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухайгаа тайлагнах шаардлагатай.

#### **Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах, залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь Компанийн үйл ажиллагааг зогсоох татан буулгахаар төлөвлөсөн эсвэл үүнээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэ нь АОУС-ын дагуух нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт

хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх, суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах, эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллагын тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болоход хүргэх нөхцөл байдлыг судлан үзсэн.
- Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд байгууллагад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авдаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц сул доголдолтой зүйлсийн талаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангаж хараат бус байдлаа хадгалан зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас завсар үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг тайланг бэлтгэлээ.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал



Ч.Эрдэнэжав

Огноо: 2026 оны 4 дүгээр сарын 15 өдөр

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 6-р хороолол, Г.Бумцэндийн гудамж, 65-р байр, 1 тоот

Утас: 70130460, 99109702, 88117655

И-мэйл хаяг: auditulziit@gmail.com

**"ТАЛХ ЧИХЭР" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2025 оны 12 сарын 31 өдөр**

|                                         | (төгрөгөөр)               |                           |
|-----------------------------------------|---------------------------|---------------------------|
| Үзүүлэлт                                | 2024 оны<br>12-р сарын 31 | 2025 оны<br>12-р сарын 31 |
| <b>ХӨРӨНГӨ</b>                          |                           |                           |
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                |                           |                           |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 5,099,664,630.67          | 311,732,422.52            |
| Дансны авлага                           | 6,705,847,623.97          | 9,548,640,961.98          |
| Татвар, НДШ-ийн авлага                  | 29,532,233.10             |                           |
| Бусад авлага                            |                           |                           |
| Бараа материал                          | 14,105,477,713.92         | 20,784,580,581.77         |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо           | 10,560,259,975.93         | 18,527,189,577.75         |
| Бусад эргэлтийн хөрөнгө                 |                           |                           |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>36,500,782,177.59</b>  | <b>49,172,143,544.02</b>  |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>            |                           |                           |
| Үндсэн хөрөнгө                          | 70,501,494,104.78         | 64,837,328,027.86         |
| Биет бус хөрөнгө                        |                           |                           |
| Биологийн хөрөнгө                       |                           |                           |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт           |                           |                           |
| Хойшлогдсон татварын хөрөнгө            |                           |                           |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө             |                           |                           |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>70,501,494,104.78</b>  | <b>64,837,328,027.86</b>  |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>107,002,276,282.37</b> | <b>114,009,471,571.88</b> |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |                           |                           |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>        |                           |                           |
| Дансны өглөг                            | 8,868,960,284.79          | 12,288,769,085.83         |
| Цалингийн өглөг                         | 1,196,593,320.23          | 972,113,399.00            |
| Татварын өр                             | 1,710,489,163.91          | 1,594,615,276.58          |
| НДШ-ийн өглөг                           |                           | 27,712,279.44             |
| Хүүний өглөг                            |                           |                           |
| Ногдол ашгийн өглөг                     | 2,310,071,543.20          | 2,194,811,593.90          |
| Урьдчилж орсон орлого                   |                           |                           |
| Бусад богино хугацаат өр төлбөр         | 868,090,440.59            |                           |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>14,954,204,752.72</b>  | <b>17,078,021,634.75</b>  |
| <b>Урт хугацаат өр төлбөр</b>           |                           |                           |
| Урт хугацаат зээл                       | 11,306,288,059.84         | 8,333,333,333.32          |
| Хойшлогдсон татварын өр                 | 829,489,223.50            |                           |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | <b>12,135,777,283.34</b>  | <b>8,333,333,333.32</b>   |
| <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            | <b>27,089,982,036.06</b>  | <b>25,411,354,968.07</b>  |
| <b>Эздийн өмч</b>                       |                           |                           |
| Өмч: -төрийн                            |                           |                           |
| -хувьцаат                               | 102,370,300.00            | 102,370,300.00            |
| Нэмж төлөгдсөн капитал                  |                           |                           |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 23,340,772,000.00         | 23,340,772,000.00         |
| Хуримтлагдсан ашиг                      | 56,469,151,946.31         | 65,154,974,303.81         |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     |                           |                           |
| <b>Эздийн өмчийн дүн</b>                | <b>79,912,294,246.31</b>  | <b>88,598,116,603.81</b>  |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>107,002,276,282.37</b> | <b>114,009,471,571.88</b> |

Аудитор



Ч.Эрдэнэжав

**"ТАЛХ ЧИХЭР" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**  
**2025 оны 12 сарын 31 өдөр**

(тогрөгөөр)

| Үзүүлэлт                                                         | 2024 оны<br>12-р сарын 31 | 2025 оны<br>12-р сарын 31 |
|------------------------------------------------------------------|---------------------------|---------------------------|
| <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>                               | 128,901,287,181.54        | 112,068,354,532.30        |
| Борлуулалтын өртөг                                               | 96,564,481,185.81         | 82,235,758,555.00         |
| <b>Нийт ашиг (алдагдал)</b>                                      | <u>32,336,805,995.73</u>  | <u>29,832,595,977.30</u>  |
| Түрээсийн орлого                                                 |                           |                           |
| Хүүний орлого                                                    |                           |                           |
| Ногдол ашгийн орлого                                             |                           |                           |
| Эрхийн шимтгэлийн орлого                                         |                           |                           |
| Бусад орлого                                                     |                           |                           |
| Борлуулалт, маркетингийн зардал                                  |                           |                           |
| Ерөнхий ба удирдлагын зардал                                     | 21,665,678,313.14         | 17,946,532,332.12         |
| Санхүүгийн зардал                                                | 509,529,110.24            | 536,139,945.94            |
| Бусад зардал                                                     |                           |                           |
| Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз)                        |                           |                           |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                       |                           |                           |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                     |                           |                           |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)                  |                           |                           |
| Бусад ашиг (алдагдал)                                            | (61,720,984.07)           | (726,620,417.13)          |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>                     | <u>10,099,877,588.28</u>  | <u>10,623,303,282.11</u>  |
| Орлогын татварын зардал                                          | 1,640,399,643.09          | 1,937,480,924.61          |
| <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>                           | <u>8,459,477,945.19</u>   | <u>8,685,822,357.50</u>   |
| <b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b> |                           |                           |
| <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>                       | <u>8,459,477,945.19</u>   | <u>8,685,822,357.50</u>   |
| <b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>                                  | -                         | -                         |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү                      |                           |                           |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                               |                           |                           |
| Бусад олз (гарз)                                                 |                           |                           |
| <b>Орлогын нийт дүн</b>                                          | <u>8,459,477,945.19</u>   | <u>8,685,822,357.50</u>   |
| <b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>               |                           |                           |

Аудитор  Ч.Эрдэнэжав



**"ТАЛХ ЧИХЭР" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2025 оны 12 сарын 31 өдөр**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт                                                                     | Өмч                   | Хөрөнгийн дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Хуримтлагдсан<br>Ашиг    | Өмчийн дүн               |
|------------------------------------------------------------------------------|-----------------------|-------------------------------------------|--------------------------|--------------------------|
| <b>2023 оны 12 -р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>                             | <b>102,370,300.00</b> | <b>23,340,772,000.00</b>                  | <b>48,009,674,001.12</b> | <b>71,452,816,301.12</b> |
| Нягтлан бодох бүртгэлийн<br>бодлогын өөрчлөлтийн нөлөө,<br>алдааны залруулга |                       |                                           |                          | -                        |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                                   | <b>102,370,300.00</b> | <b>23,340,772,000.00</b>                  | <b>48,009,674,001.12</b> | <b>48,112,044,301.12</b> |
| Бусад дэлгэрэнгүй орлого                                                     |                       |                                           |                          |                          |
| Өмчид гарсан өөрчлөлт                                                        |                       |                                           |                          |                          |
| Зарласан ногдол ашиг                                                         |                       |                                           |                          |                          |
| Тайлант үеийн цэвэр ашиг,<br>алдагдал                                        |                       |                                           | 8,459,477,945.19         | 8,459,477,945.19         |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн<br>хэрэгжсэн дүн                                 |                       |                                           |                          | -                        |
| <b>2024 оны 12-р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>                              | <b>102,370,300.00</b> | <b>23,340,772,000.00</b>                  | <b>56,469,151,946.31</b> | <b>79,912,294,246.31</b> |
| Нягтлан бодох бүртгэлийн<br>бодлогын өөрчлөлтийн нөлөө,<br>алдааны залруулга |                       |                                           |                          | -                        |
| <b>Залруулсан үлдэгдэл</b>                                                   | <b>102,370,300.00</b> | <b>23,340,772,000.00</b>                  | <b>56,469,151,946.31</b> | <b>79,912,294,246.31</b> |
| Тайлант үеийн цэвэр ашиг                                                     |                       |                                           | 8,685,822,357.50         | 8,685,822,357.50         |
| Бусад дэлгэрэнгүй орлого                                                     |                       |                                           |                          | -                        |
| Өмчид гарсан өөрчлөлт                                                        |                       |                                           | -                        | -                        |
| Зарласан ногдол ашиг                                                         |                       |                                           |                          | -                        |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн<br>хэрэгжсэн дүн                                 |                       |                                           |                          | -                        |
| <b>2025 оны 12-р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>                              | <b>102,370,300.00</b> | <b>23,340,772,000.00</b>                  | <b>65,154,974,303.81</b> | <b>88,598,116,603.81</b> |

Аудитор



Ч.Эрдэнэжав

**"ТАЛХ ЧИХЭР" ХК**  
**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2025 оны 12 сарын 31 өдөр**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт                                                     | 2024 оны<br>12-р сарын 31 | 2025 оны<br>12-р сарын 31 |
|--------------------------------------------------------------|---------------------------|---------------------------|
| <b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                 |                           |                           |
| <i>Мөнгөний орлогын дүн</i>                                  | <b>125,445,813,474.66</b> | <b>110,917,298,947.56</b> |
| Бараа борлуулсаны, үйлчилгээ үзүүлсний орлого                | 125,445,813,474.66        | 110,917,298,947.56        |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого                    |                           |                           |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                       |                           |                           |
| Буцаан авсан албан татвар                                    |                           |                           |
| Татаас, санхүүжилтийн орлого                                 |                           |                           |
| Бусад мөнгөн орлого                                          |                           |                           |
| <i>Мөнгөн зарлагын дүн</i>                                   | <b>130,491,695,034.74</b> | <b>111,615,527,254.47</b> |
| Ажиллагчдад төлсөн мөнгө                                     | 17,076,237,912.27         | 18,095,050,033.85         |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө                 | 5,458,717,140.81          | 5,469,960,420.63          |
| Бараа материал худалдан авахад төлсөн                        | 97,264,843,058.80         | 69,078,982,601.59         |
| Ашиглалтын зардалд төлсөн                                    |                           |                           |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө  |                           |                           |
| Хүүний төлбөрт төлсөн                                        | 509,529,110.24            | 536,139,945.94            |
| Татварын байгууллагад төлсөн                                 | 1,653,209,926.85          | 1,164,655,726.19          |
| Даатгалын төлбөрт төлсөн                                     |                           |                           |
| Бусад мөнгөн зарлага                                         | 8,529,157,885.77          | 17,270,738,526.27         |
| <i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>    | <b>(5,045,881,560.08)</b> | <b>(698,228,306.91)</b>   |
| <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>     |                           |                           |
| <i>Мөнгөн орлогын дүн</i>                                    | <b>6,254,387.01</b>       | <b>20,452,782.93</b>      |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                             |                           |                           |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого                           |                           |                           |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого                 |                           |                           |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт       |                           |                           |
| Хүлээн авсан хүүний орлого                                   | 6,254,387.01              | 20,452,782.93             |
| Хүлээн авсан ногдол ашиг                                     |                           |                           |
| <i>Мөнгөн зарлагын дүн</i>                                   | -                         | -                         |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                          |                           |                           |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                        |                           |                           |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн                        |                           |                           |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа                         |                           |                           |
| <i>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</i>        | <b>6,254,387.01</b>       | <b>20,452,782.93</b>      |
| <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>             |                           |                           |
| <i>Мөнгөн орлогын дүн</i>                                    | <b>13,290,498,883.63</b>  | <b>4,700,000,000.00</b>   |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан          | 13,244,958,064.72         | 4,700,000,000.00          |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан |                           |                           |
| Төрөл бүрийн хандив                                          | 45,540,818.91             |                           |
| <i>Мөнгөний зарлагын дүн</i>                                 | <b>3,133,520,542.96</b>   | <b>8,515,092,367.22</b>   |
| Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө           | 3,065,785,863.16          | 7,958,477,346.90          |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн                           |                           |                           |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн                        |                           |                           |
| Төлсөн ногдол ашиг                                           | 67,734,679.80             | 548,431,020.32            |
| Бусад                                                        |                           | 8,184,000.00              |
| <i>Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн</i>                      | <b>10,156,978,340.67</b>  | <b>(3,815,092,367.22)</b> |
| Валютын ханшийн зөрүү                                        | (115,217,806.63)          | (295,064,316.95)          |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                              | <b>5,002,133,360.97</b>   | <b>(4,787,932,208.15)</b> |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл             | 97,531,269.70             | 5,099,664,630.67          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл            | 5,099,664,630.67          | 311,732,422.52            |

Аудитор



Эрдэнэжав

## 1. Байгууллагын талаарх мэдээлэл

|                          |                                                                                                                                                                                                                                                                                                             |
|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Байгууллагын нэр:        | "Талх Чихэр" ХК                                                                                                                                                                                                                                                                                             |
| Үүсгэн байгуулах шийдвэр | Талх Чихэр ХК нь 1365 тоот тогтоолоор 1991.11.02 байгуулагдсан<br>Гишүүдийн тоо: 4190<br>Дүрмийн сан: 102,370.3 мянган төгрөг                                                                                                                                                                               |
| Гэрчилгээ                | РД: 2074575<br>Улсын бүртгэлийн дугаар: 9010001092                                                                                                                                                                                                                                                          |
| Үндсэн үйл ажиллагаа     | Талх, нарийн боовны үйлдвэрлэл худалдаа<br>Хатуу, зөөлөн чихрийн үйлдвэрлэл, худалдаа                                                                                                                                                                                                                       |
| Гүйцэтгэх Удирдлага      | Гүйцэтгэх захирал М.Базар-Ууган                                                                                                                                                                                                                                                                             |
| ТУЗ                      | Бүх нийтийн хурлаар 5 гишүүнийг сонгосон.<br>➤ ТУЗ-ийн дарга Д.Баярсайхан<br>➤ Нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр<br>➤ Гишүүн Б.Намуун<br>➤ Гишүүн Б.Оргил<br>➤ Гишүүн Э.Цэцэглэн<br>➤ Гишүүн Б.Саруул<br>➤ Гишүүн Ли Гоф Дидер<br>➤ Гишүүн Х.Баттуул<br>➤ Гишүүн Х.Цэндбаяр<br>➤ Хараат бус гишүүн Т.Золбаяр |
| Хаяг:                    | Монгол Улс, Улаанбаатар хот: Сонгинохайрхан дүүрэг 29-р хороо,<br>өөрийн төв байр<br>Утас: 72888888,                                                                                                                                                                                                        |

## ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2026.04.15

Монгол Улсын Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4 дэх заалтыг үндэслэн "Талх Чихэр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд гэрээний дагуу санхүүгийн тайлангийн аудитыг Өлзий Экаунт Аудит ХХК-ийн захирал Ч.Эрдэнэжав удирдан аудитор Ч.Оюун аудитын багийг ахалж хийлээ.

Манай аудитын баг тухайн байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй болно.

"Талх Чихэр" ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь бидний зорилт байв.

"Талх Чихэр" ХК нь санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.

Бид аудитаа "Аудитын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Татварын багц хууль", "Нийгмийн даатгалын багц хууль", "Компанийн тухай хууль" болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт, НББОУС-ын зарчмуудад нийцүүлэн боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.

Аудит нь тухайн байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан аж ахуй нэгж байгууллагын дансны жагсаалт, заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт бусад хууль журмыг шалгуур болгон ашиглав.

"Талх Чихэр" ХК-ийн санхүүгийн тайланг материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл нотолгоо олж авахын тулд хөрөнгийн орлого, зардлыг түүвэрчлэн шалгах аудитын горимыг хэрэгжүүлж, аудитын явцад нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

Аудитын явцад байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан шалгасан нь санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах үндэслэл болж байна.

### Материаллаг байдал:

Талх Чихэр" ХК-ийн материаллаг байдлын түвшин төлөвлөлтийн үе шатанд 2025 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 100,182.3 сая төгрөгийг сонгож эрсдэлийн үнэлгээг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг зардлын 1% буюу 1,120.7 сая төгрөг аудитын эрсдэлтэй уялдан тооцож гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70% -ийг сонгох

зүйтэй гэж үзсэн бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдал 827.6 сая төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлт ороогүй болно.

#### **Байгууллагын үйл ажиллагааны талаар:**

Талх Чихэр" ХК нь 1984 онд "Талх Чихрийн комбинат" нэртэйгээр анх ЗХУ-н техник, эдийн засгийн туслалцаатайгаар Улаанбаатар хотод ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Монголын хүнсний манлайлагч үйлдвэр юм.

Талх Чихэр компанийн компанийн төрийн мэдлийн 70%-ийг хувьчлан авч 1991 оны 11 дүгээр сарын 02-нд (регистрийн дугаар: 2074575, улсын бүртгэлийн дугаар: 9010001092) Талх Чихэр ХК болж бүртгэгдсэн.

Талх Чихэр" ХК нь 1984 онд "Талх Чихрийн комбинат" нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1999 онд 100% хувьчлагдаж, 3000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын топ аж ахуй нэгжийн нэг юм.

Эрүүл хүнс Таны сонголт уриатай "Талх Чихэр" ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 4 шугам, жигнэмэг, чихрийн шугам бүхий "Томбат" ХХК, бялуу, бэйкери төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх "Хотол" бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний үйлдвэрлэлийн нэг юм.

Тус үйлдвэрлэл нь 10 гаруй нэр төрлийн талх, 20 гаруй нэр төрлийн нарийн боов, төрөл бүрийн бялуу, 10 гаруй нэр төрлийн жигнэмэг, 10 гаруй төрлийн зөөлөн чихэр, мармелад, зөөлөн чихрийн цуглуулга үйлдвэрлэж өдөр тутам Улаанбаатар хотын 3000 гаруй цэгт түгээж байна.

Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Франц, Герман Голланд, Испани, Финланд, Австрали гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн автомат тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа нэвтрүүлж, бусдаас тэргүүлэх зэргийн үйлдвэр болж үйл ажиллагаагаа улам өргөжүүлж байна.

**Алсын хараа:** Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

**Эрхэм зорилго:** Хүний хөгжил, менежментийн бодлогоор тэргүүлэгч, хүнсний салбарын загвар компани байна.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

- Хүнсний үйлдвэрлэл
- Худалдаа
- Хатуу, зөөлөн чихрийн үйлдвэрлэл
- худалдаа эрхэлдэг.

#### **Үнэт зүйл:**

- Тэргүүн технологи
- Аюулгүй бүтээгдэхүүн
- Чадварлаг ажилтан

- Итгэлцэл, түншлэл
- 2015 оны 11 сарын 22-нд нийт хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг тогтмол өндөрт байлгах зорилгоор Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008 олон улсын стандартыг "Салбартаа анх удаа" нэвтрүүлсэн.
- ISO 22000:2018" ХАБМТ-ны стандарт дээр тулгуурлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор "FSSC 22000"– хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.
- "MNS ISO 45001:2018" ХЭМАБМТ-ны стандартын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэж, үйл ажиллагаандаа нутагшуулан, сургалт хөгжүүлэлтийг тогтмолжуулж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт /KPI/-р үнэлэх системийг сайжруулна.

#### **Төлөөлөн удирдах зөвлөл:**

2024 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол №1

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

- Х.Баттуул
- Х.Цэндбаяр
- Б.Саруул
- Б.Намуун
- Le Goff Didier

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

- Д.Баярсайхан
- Т.Золбаяр
- Б.Оргил нарыг сонгож компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгосон байна.

Компанийн ТУЗ нь 2025 онд удаа хуралдаж тогтоол шийдвэр гаргасан байна ТУЗ-ын дэргэдэх нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, аудитын хороо ажиллаж байна.

2025 оны 04 сарын 21-нд бүх гишүүдийн хурлыг хуралдуулж дараах асуудлыг хэлэлцсэн байна.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын өгсөн дүгнэлт
- Компанийн 2025 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах.
- ТУЗ-ын 2025 оны төсвийг батлах.

Үүнд:

Талх чихэр" ХК нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 46.1дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн дугаар 03 тогтоолын дагуу компанийн 2025 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт, хэтийн төлөвийг харгалзан нэгж хувьцаанд 450 (дөрвөн зуун тавь) төгрөгөөр тооцож, ногдол ашиг хуваарилахаар болсон байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, ногдол ашгийг 2026 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулахаа мэдэгдсэн байна.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн I ангилалд бүртгэлтэй "Талх Чихэр" ХК-ийн Маркетингийн албаны ахлах менежер Б.Амаржаргал, Нягтлан бодогч И.Түвшинжаргал нар 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн үр дүнгээ танилцуулсан.

Талх Чихэр ХК-ийн 2025 оны 09 дугаар сарын 26-ээрх Үнэт цаас эзэмшигчийн хураангуй судалгаагаар нийт 73 ҮЦК-нд 1,023,359 ширхэг хувьцаа байршиж байна.

**Нийт хувьцаа:** 1,023,703 ширхэг хувьцаа гаргаснаас 344 ширхэг хувьцаа арилжаалагдаагүй 1,023,359 хувьцааг гаргаж 5-аас дээш хувийн хувьцааг дараах нэр бүхий хүмүүс эзэмшиж байна.

#### НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

/МХБ-ын 2026 оны 02 сарын 26-ны судалгаагаар/

| №   | Хувьцаа эзэмшигч       | тоо  | Хувьцааны тоо | Хувь  |
|-----|------------------------|------|---------------|-------|
| 1   | Х.Баттуул              | 1    | 340,000       | 33.21 |
| 2   | Х.Цэндбаяр             | 1    | 195,901       | 19.14 |
| 3   | Х.Баттулга             | 1    | 193,886       | 18.94 |
| 4   | Б.Эрхэс                | 1    | 151,140       | 14.03 |
| 5   | Жижиг хувьцаа эзэмшигч | 3960 | 142,432       | 13.95 |
| 6   | Гаргаагүй хувьцаа      |      | 344           |       |
| Дүн |                        | 3964 | 1,023,703     | 100   |

**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн түүх**

| № | Овог Нэр         | Хувь    | Огноо      |
|---|------------------|---------|------------|
| 1 | Баттуул Эрхэс    | 14.3 %  | 2023-08-08 |
| 2 | Халтмаа Цэндбаяр | 19.14 % | 2020-06-02 |
| 3 | Халтмаа Баттулга | 18.94 % | 2018-07-31 |
| 4 | Халтмаа Баттуул  | 33.21 % | 2018-07-31 |

#### ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал Базар-Ууган 1-р гарын үсэг, нягтлан бодогч Б.Гандулам 2 дугаар гарын үсэг зурж үйл ажиллагааг явуулж ирсэн байна. Тайлант онд санхүүгийн программ хангамж өөрчлөөгүй байна.

- Санхүүгийн тайлангийн зорилго:** Санхүүгийн тайлан нь гадаад болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч, өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр

дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний)-ийн талаарх мэдээллээр хангана.

2. **Санхүүгийн тайланд хүлээх хариуцлага:** Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ.
3. **Санхүүгийн тайлан бэлтгэх суурь:** Тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бэлтгэдэг.
4. Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байна.
5. **Санхүүгийн тайлан бэлтгэх суурь:** Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/-д нийцүүлэн 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Сангийн сайдын 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар аргачлалын дагуу гаргаж, "Санхүүгийн тайлангийн А маяг", Санхүүгийн тайлангийн Б маяг"-аар тайлагнаж байна.
  - a. Тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар бэлтгэдэг.
  - b. Санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн тодорхой санхүүгийн хэрэглүүрээс бусад нь түүхэн өртгөөр бэлтгэдэг.
  - c. **Үйл ажиллагааны ба толилуулгын валют:** Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
  - d. **Гадаад валютаарх ажил гүйлгээ:** Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагнасан өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд хэрэв аж ахуйн нэгжийн толилуулгын валют бүртгэлийн валютаас өөр байвал тэрээр үр дүн, санхүүгийн байдлаа толилуулгын валют уруу хөрвүүлэх ба үүссэн ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.
6. **Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн:** Иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
  - Санхүүгийн байдлын тайлан;
  - Орлогын дэлгэрэнгүй тайлан;
  - Өмчийн өөрчлөлтийн тайлан;
  - Мөнгөн гүйлгээний тайлан;
  - Санхүүгийн тайлангийн тодруулга
7. **Санхүүгийн тайлангийн толилуулга:**

Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлүүдийг шинж чанар эсвэл үүргээс хамааран ижил зүйлүүдийн дүнтэй нэгтгэн толилуулсан байна.

- Талх Чихэр ХК нь өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө болон богино хугацаат, урт хугацаат өр төлбөрийг санхүүгийн тайланд тусад нь ангилан, тодорхой хугацаагаар (сар, улирал, жил) тасалбар болгон толилуулна.

- Санхүүгийн байдлын тайлангийн зүйл ангийг тайлант жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж байна.
- Тайлагнагч аж ахуйн нэгжийн нэр, өмнөх тайлант үеийн эцсийн мэдээлэл дэх аливаа өөрчлөлт
- Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан болох тухай
- Тайлант үеийн эцсийн өдөр, санхүүгийн тайлан эсхүл тодруулгын хамрах хугацаа
- Толилуулгын валют

## 8. Санхүүгийн байдлын тайланг хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө гэж ангилж бүртгэж байна.

### а) Хөрөнгийн ангилал:

- Эргэлтийн хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө

### б) Өр төлбөрийн ангилал:

- Богино хугацаат өр
- Урт хугацаат өр

в) **Өмч:** Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч *өмчийг* хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд өмчийг төрийн болон хувийн өмч гэж ангилж толилуулна.

- Төрийн
- Хувийн гэж ангилж толилуулна.

### 2.1. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

#### (i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө

Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан гм)-тай холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

#### (ii) Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө

Бодит хөрөнгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтын өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

## 2.2. Санхүүгийн өр төлбөр

Байгууллага ар төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр ангилдаг.

- ❖ Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ❖ Бусад санхүүгийн өр төлбөр

*Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсгэн хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

## 2.3. Үндсэн хөрөнгө

*Анхны хүлээн зөвшөөрөх ба хэмжилт*

Бүх үндсэн хөрөнгө дараа үед түүхэн өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгагдана. Анхдагч хэмжилтийн өртөг хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн өртөгт гадаад валютаар худалдан авсан үндсэн хөрөнгийн мөнгөн урсгалын олз/гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэрэг болно.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг оруулсан үед дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээний холбоотой гарсан зардлыг гарсан үед тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулсан тодорхойлсон ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

### *Дараа үеийн зардал*

Сольж тавьсан эд анги, хэсэг нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж байгууллагад өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэнд нэмж хүлээн зөвшөөрнө.

Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

## Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба элэгдүүлэх хугацааг доор харуулсан болно.

- ✚ Барилга байгууламж 30-40 жил
- ✚ Тавилга эд хогшил 5-10 жил
- ✚ Тоног төхөөрөмж 10 жил
- ✚ Тээврийн хэрэгсэл 10 жил
- ✚ Компьютер дагалдах хэрэгсэл 3-5 жил
- ✚ Бусад хөрөнгө 10 жил

### 2.4. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэнэ буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно. Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ.

Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүнгийн аль ихээр тооцно. Ашиглалтын үнэ цэнэ нь татварын өмнөх дискаунтын түвшин (мөнгөний үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн эрсдэл зэргийг агуулсан)-г ашиглан ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс ил бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

### 2.5. Цэвэр хөрөнгө

#### Нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм.

#### Хуримтлагдсан үр дүн

Үүсгэн байгуулагдсанаас хойших хугацаанд тус байгууллагад хуримтлагдсан эерэг, сөрөг үр дүнгийн нийлбэрийг хуримтлагдсан үр дүн дансанд бүртгэх ба анхны оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

### 2.6. Орлого

Орлогыг үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого нь гишүүдийн татвар, хөтөлбөр төслийн орлого болон бэлэг, хандив тусламжийн орлогоос бүрдэнэ. Гишүүдээс орж ирсэн гишүүний татварын орлого болон бусад орлогыг дараах нөхцөл бүрдсэн үед хүлээн зөвшөөрнө.

- ✓ Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байх;
- ✓ Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай байх;
- ✓ Балансын өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг бодитойгоор тооцох боломжтой;

- ✓ Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал болон ажил гүйлгээг гүйцээхэд гарсан өртгийг найдвартай хэмжих боломжтой байх;

#### *Хүүний орлого*

Хүүний орлогыг үндсэн зээл буюу хэрэглүүрийн үлдэгдэл болон холбогдох харилцах хадгаламжийн үлдэгдлээс үр ашигтай хүүний түвшнээр тооцож, аккрузал сууриар хүлээн зөвшөөрнө.

#### **2.7. Зардал**

Тайлант хугацаанд мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан жилд нь үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

#### **2.8. Санхүүгийн орлого зардал**

Санхүүгийн орлогод харилцах, хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүүний орлого, бараа бүтээгдэхүүн борлуулсны орлог зэргийг хамруулна. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлого олсон тайлант үеийнх нь үр дүнгийн тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүний зардлыг хамруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлттэй шууд хамааралтай капиталжуулсан зээлийн өртгөөс бусад бүр зээлийн хүүний зардлыг үр ашигт хүүний аргыг ашиглан тайлант үеийнх нь үр дүнгийн тайлан тусгана.

#### *Зээлийн хүүний зардал*

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах эсвэл үйлдвэрлэхтэй шууд холбоотой тусгай болон ердийн зээлийн хүүний зардлыг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгох зорилгоор хөрөнгийг бэлтгэх болон бүрэн дуусгахад шаардлагатай хугацааны туршид капиталжуулна. Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгө гэдэг нь хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болтол тодорхой хугацаа шаардлагатай хөрөнгийг хэлнэ.

Бэлтгэл ажиллагаа шаардлагатай хөрөнгийг зарцуулалтад тодорхой зээл авч богино хугацааны хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг капиталжуулах зээлийн хүүний зардлаас хасна.

#### *Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл*

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон авлага, өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаадад валютын ханшийн зөрүүг ерөнхийдөө ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Зээлтэй холбоотой ханшийн зөрүүний олз, гарзыг үр дүнгийн тайланд санхүүгийн зардалд багтаан тайлагнана. Бусад ханшийн зөрүүний олз, гарзыг үр дүнгийн тайланд бусад орлого эсвэл бусад зардлын цэвэр дүнгээр тайлагнана.

#### **2.9. Түрээс**

Түрээсийн үүрэг хариуцлагыг санхүүгийн зардлыг хассан цэвэр дүнгээр нь бусад богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн хэсэгт харуулдаг. Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардал гэсэн 2 хэсэгт ангилна. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид үр дүнгийн тайланд тусгах ба тайлант хугацаа бүрийн хувьд өр

төлбөрийн үлдэгдэлд тооцогдох тогтмол хугацааны хүүг тооцоолох шаардлагатай. Санхүүгийн түрээсээр олж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаанд эсвэл түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ.

Түрээсийн хөрөнгийн эрсдэл ба өгөөжийн дийлэнх хувийг хүртэхээргүй бол үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг. Үйл ажиллагааны түрээсийн төлбөр (түрээслүүлэгчээс үзүүлсэн урамшууллыг хассан цэвэр дүнгээр)-ийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар үр дүнгийн тайланд тусгана.

#### 2.10. Ажилчдын тэтгэмж

Ажилтан байгууллагад үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Ажилтны үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас хойш арван хоёр сараас илүү хугацаанд төлөгдөх бусад урт хугацааны тэтгэмжид удаан жил ажилласны тэтгэмж болон жилийн амралт зэрэг багтах ба төлөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тайлант жилийн эцэс хүртэл үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр дэмжинэ.

Стандартаар заасан бусад хэлбэрүүд болох ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдсаны тэтгэмж нь Монгол улсын холбогдох хуулийн дагуу төрөөс төлөгддөг бөгөөд байгууллагын хувьд төлбөр төлөх үүрэг хүлээдэггүй.

#### 2.11. Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын үр дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэх, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хэлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

#### 2.12. Татварын бүртгэл

Аж ахуйн нэгж байгууллагын албан татвар төлөгч, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч байгууллага юм. Байгууллагын ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол улсын "Нийгмийн даатгалын тухайн" хуулийн дагуу, хувь хүний орлогын албан татварыг "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу тогтоосон хувь хэмжээгээр суутган авч харьяалагдах татвар, нийгмийн даатгалын хэлтэст төлж тайлагнана. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэгдэнэ.

#### 2.13. Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. СТОУС-аар байгууллага нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой тал болох ба хэрвээ тухайн этгээд нь өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГААР

мян.төгрөг

| ҮЗҮҮЛЭЛТ                                | 2024 оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 | Өмнөх онтой харьцуулсан + /өссөн/ - /буурсан/ | Нийт хөрөнгөнд харьцуулсан |
|-----------------------------------------|----------------------|----------------------|-----------------------------------------------|----------------------------|
| <b>ХӨРӨНГӨ</b>                          |                      |                      |                                               |                            |
| <b>1. Эргэлтийн хөрөнгө</b>             |                      |                      |                                               |                            |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө         | 5,099,664.6          | 311,732.4            | (4,787,932.2)                                 | (0.7)                      |
| Дансны авлага                           | 6,705,847.6          | 9,548,641.0          | 2,842,793.3                                   | 0.4                        |
| Татвар, НДШ-ийн авлага                  | 29,532.2             | -                    | (29,532.2)                                    | (0.0)                      |
| Бараа материал                          | 14,105,477.7         | 20,784,580.6         | 6,679,102.9                                   | 1.0                        |
| Урьдчилж төлсөн зардал /тооцоо          | 10,560,260.0         | 18,527,189.6         | 7,966,929.6                                   | 1.1                        |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>          | <b>36,500,782.2</b>  | <b>49,172,143.5</b>  | <b>12,671,361.4</b>                           | <b>1.8</b>                 |
| <b>2.Эргэлтийн бус хөрөнгө</b>          |                      |                      |                                               |                            |
| Үндсэн хөрөнгө                          | 70,501,494.1         | 64,837,328.0         | (5,664,166.1)                                 | (0.8)                      |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>      | <b>70,501,494.1</b>  | <b>64,837,328.0</b>  | <b>(5,664,166.1)</b>                          | <b>(0.8)</b>               |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b>107,002,276.3</b> | <b>114,009,471.6</b> | <b>7,007,195.3</b>                            | <b>1.0</b>                 |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>          |                      |                      |                                               |                            |
| <b>3. Богино хугацаат өр төлбөр</b>     |                      |                      |                                               |                            |
| Дансны өглөг                            | 8,868,960.3          | 12,288,769.1         | 3,419,808.8                                   | 0.4                        |
| Цалингийн өглөг                         | 1,196,593.3          | 972,113.4            | (224,479.9)                                   | (0.0)                      |
| Татварын өр                             | 1,710,489.2          | 1,594,615.3          | (115,873.9)                                   | (0.0)                      |
| НДШ-ийн өглөг                           | -                    | 27,712.3             | 27,712.3                                      | 0.0                        |
| Ногдол ашгийн өглөг                     | 2,310,071.5          | 2,194,811.6          | (115,259.9)                                   | (0.0)                      |
| Бусад богино хугацаат өр төлбөр         | 868,090.4            | -                    | (868,090.4)                                   | (0.1)                      |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>14,954,204.8</b>  | <b>17,078,021.6</b>  | <b>2,123,816.9</b>                            | <b>0.1</b>                 |
| <b>4. Урт хугацаат өр төлбөр</b>        |                      |                      |                                               |                            |
| Урт хугацаат зээл                       | 11,306,288.1         | 8,333,333.3          | (2,972,954.7)                                 | 0.1                        |
| Хойшлогдсон татварын өр                 | 829,489.2            | -                    | (829,489.2)                                   | -                          |
| Бусад урт хугацаат өр төлбөр            | 829,489.2            | -                    | -                                             | -                          |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | <b>12,135,777.3</b>  | <b>8,333,333.3</b>   | <b>(3,802,444.0)</b>                          | <b>0.1</b>                 |
| <b>Өр төлбөрийн нийт дүн</b>            | <b>27,089,982.0</b>  | <b>25,411,355.0</b>  | <b>(1,678,627.1)</b>                          | <b>0.2</b>                 |
| <b>5. Эзэмшигчийн өмч</b>               |                      |                      |                                               |                            |
| - хувьцаат                              | 102,370.3            | 102,370.3            | -                                             | -                          |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 23,340,772.0         | 23,340,772.0         | -                                             | -                          |
| Хуримтлагдсан ашиг                      | 56,469,151.9         | 65,154,974.3         | 8,685,822.4                                   | 0.6                        |
| <b>Эзэмшигчийн өмчийн дүн</b>           | <b>79,912,294.2</b>  | <b>88,598,116.6</b>  | <b>7,007,195.3</b>                            | <b>0.8</b>                 |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>107,002,276.3</b> | <b>114,009,471.6</b> | <b>8,685,822.4</b>                            | <b>1.0</b>                 |

Нийт хөрөнгө тайлант онд 114,009,471.6 мянган төгрөг болж өмнөх оноос 8,685,822.4 мянган төгрөгөөр өссөн нь дансны авлага, 2,842,793.3 мянган төгрөгөөр бараа материалын үлдэгдэл 6,679,102.9 мянган төгрөгөөр, урьдчилж төлсөн зардал 7,966,929.6 мянган төгрөгөөр, тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Орлого:

мян. төг

| Орлого, санхүүжилтийн эх үүсвэр | Өмнөх оны гүйцэтгэл  |               | Тайлант оны гүйцэтгэл |              | Зөрүү                 |              |
|---------------------------------|----------------------|---------------|-----------------------|--------------|-----------------------|--------------|
|                                 | Дүн                  | хувийн        | Дүн                   | хувийн       | Өмнөх оноос           |              |
|                                 |                      | жин           |                       | жин          | Дүн                   | Хувь         |
| Борлуулалтын орлого(цэвэр)      | 128,901,287.2        | 100.00        | 112,068,354.5         | 100.00       | (16,832,932.6)        | 100.00       |
| Түрээсийн орлого                | -                    | -             | -                     | -            | -                     | -            |
| <b>Нийт орлого</b>              | <b>128,901,287.2</b> | <b>100.00</b> | <b>112,068,354.5</b>  | <b>100.0</b> | <b>(16,832,932.6)</b> | <b>100.0</b> |

Борлуулалтын орлого тайлант онд 112,068,354.5 мянган төгрөг болж өмнөх оноос 16,832,932.6 мянган төгрөгөөр буурсан нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ буурсан тоног төхөөрөмж их засвар хийсэнтэй холбоотой байна.

Зардал:

мян.төгрөг

| Эдийн засгийн ангилал           | Өмнөх оны гүйцэтгэл  |               | Тайлант жил          |               | Зөрүү               |               |
|---------------------------------|----------------------|---------------|----------------------|---------------|---------------------|---------------|
|                                 | Дүн                  | хувийн<br>жин | Дүн                  | хувийн<br>жин | Өмнөх оноос         |               |
|                                 |                      |               |                      |               | Дүн                 | Хувь          |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 96,564,481.2         | 81.28         | 82,235,758.6         | 81.06         | 14,328,722.6        | 126.79        |
| Борлуулалт маркетингийн зардал  | -                    | -             | -                    | -             | -                   | -             |
| Ерөнхий ба удирдлагын зардал    | 21,665,678.3         | 18.24         | 17,946,532.3         | 17.69         | (3,719,146.0)       | (32.91)       |
| Бусад зардал                    | -                    | -             | -                    | -             | -                   | -             |
| Санхүүгийн зардал               | 509,529.1            | 0.43          | 536,139.9            | 0.53          | 26,610.8            | 0.24          |
| Бусад ашиг ( алдагдал)          | 61,721.0             | 0.05          | 726,620.4            | 0.72          | 664,899.4           | 5.88          |
| <b>Нийт зарлагын дүн</b>        | <b>118,801,409.6</b> | <b>100.00</b> | <b>101,445,051.3</b> | <b>100.00</b> | <b>11,301,086.9</b> | <b>100.00</b> |

Нийт зардал тайлант онд 101,445,051.3 мянган төгрөг болж өмнөх оноос 11,301,086.9 мянган төгрөгөөр буурсан нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний орлого буурсантай холбоотой байна.

– Болзошгүй зүйл

2025 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭЖАВ

**2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ**

| <b>Талх Чихэр ХК</b><br>(Байгууллагын нэр)            |  | <b>СТА/2025/ 120</b>        |                             | <b>/төгрөг/</b>                                                 |                                           |
|-------------------------------------------------------|--|-----------------------------|-----------------------------|-----------------------------------------------------------------|-------------------------------------------|
| <b>ҮЗҮҮЛЭЛТ</b>                                       |  | <b>2024 оны 12 сарын 31</b> | <b>2025 оны 12 сарын 31</b> | <b>Өмнөх онтой<br/>харьцуулсан<br/>+ /эсвэл<br/>- /буурсан/</b> | <b>Нийт<br/>хөрөнгөнд<br/>харьцуулсан</b> |
| <b>ХӨРӨНГӨ</b>                                        |  |                             |                             |                                                                 |                                           |
| <b>1.Эргэлтийн хөрөнгө</b>                            |  |                             |                             |                                                                 |                                           |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө                       |  | 5,099,664,630.67            | 311,732,422.52              | (4,787,932,208.15)                                              | (0.7)                                     |
| Дансны авлага                                         |  | 6,705,847,623.97            | 9,548,640,961.98            | 2,842,793,338.01                                                | 0.4                                       |
| Татвар, НДШ-ийн авлага                                |  | 29,532,233.10               | -                           | (29,532,233.10)                                                 | (0.0)                                     |
| Бусад авлага                                          |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Бусад санхүүгийн хөрөнгө                              |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Бараа материал                                        |  | 14,105,477,713.92           | 20,784,580,581.77           | 6,679,102,867.85                                                | 1.0                                       |
| Урьдчилж төлсөн зардал /тооцоо                        |  | 10,560,259,975.93           | 18,527,189,577.75           | 7,966,929,601.82                                                | 1.1                                       |
| Бусад эргэлтийн хөрөнгө                               |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                        |  | <b>36,500,782,177.59</b>    | <b>49,172,143,544.02</b>    | <b>12,671,361,366.43</b>                                        | <b>1.8</b>                                |
| <b>2.Эргэлтийн бус хөрөнгө</b>                        |  |                             |                             |                                                                 |                                           |
| Үндсэн хөрөнгө                                        |  | 70,501,494,104.78           | 64,837,328,027.86           | (5,664,166,076.92)                                              | (0.8)                                     |
| Биет бус хөрөнгө                                      |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Биологийн хөрөнгө                                     |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                         |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө                         |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Хойшлогдсон татварын хөрөнгө                          |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө     |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                           |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| Дуусаагүй барилга                                     |  | -                           | -                           | -                                                               | -                                         |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                    |  | <b>70,501,494,104.78</b>    | <b>64,837,328,027.86</b>    | <b>(5,664,166,076.92)</b>                                       | <b>(0.8)</b>                              |

| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН                                                                                    |                          |                          |                           | 114,009,471,571.88 | 7,007,195,289.51 | 1.0        |
|-------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|---------------------------|--------------------|------------------|------------|
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>                                                                        |                          |                          |                           |                    |                  |            |
| <b>3. Богино хугацаат өр төлбөр</b>                                                                   |                          |                          |                           |                    |                  |            |
| Дансны өглөг                                                                                          | 8,868,960,284.79         | 12,288,769,085.83        | 3,419,808,801.04          |                    |                  | 0.4        |
| Цалингийн өглөг                                                                                       | 1,196,593,320.23         | 972,113,399.00           | (224,479,921.23)          |                    |                  | (0.0)      |
| Татварын өр                                                                                           | 1,710,489,163.91         | 1,594,615,276.58         | (115,873,887.33)          |                    |                  | (0.0)      |
| НДШ-ийн өглөг                                                                                         | -                        | 27,712,279.44            | 27,712,279.44             |                    |                  | 0.0        |
| Богино хугацаат зээл                                                                                  | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Хүүний өглөг                                                                                          | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Ногодол ашгийн өглөг                                                                                  | 2,310,071,543.20         | 2,194,811,593.90         | (115,259,949.30)          |                    |                  | (0.0)      |
| Урьдчилж орсон орлого                                                                                 | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Нөөц /өр төлбөр/                                                                                      | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Бусад богино хугацаат өр төлбөр                                                                       | 868,090,440.59           | -                        | (868,090,440.59)          |                    |                  | (0.1)      |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>                                                               | <b>14,954,204,752.72</b> | <b>17,078,021,634.75</b> | <b>2,123,816,882.03</b>   |                    |                  | <b>0.1</b> |
| <b>4. Урт хугацаат өр төлбөр</b>                                                                      |                          |                          |                           |                    |                  |            |
| Урт хугацаат зээл                                                                                     | 11,306,288,059.84        | 8,333,333,333.32         | (2,972,954,726.52)        |                    |                  | 0.1        |
| Нөөц /өр төлбөр/                                                                                      | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Хойшлогдсон татварын өр                                                                               | 829,489,223.50           | -                        | (829,489,223.50)          |                    |                  | -          |
| Бусад урт хугацаат өр төлбөр                                                                          | 829,489,223.50           | -                        | -                         |                    |                  | -          |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>                                                                  | <b>12,135,777,283.34</b> | <b>8,333,333,333.32</b>  | <b>(3,802,443,950.02)</b> |                    |                  | <b>0.1</b> |
| <b>Өр төлбөрийн нийт дүн</b>                                                                          | <b>27,089,982,036.06</b> | <b>25,411,354,968.07</b> | <b>(1,678,627,067.99)</b> |                    |                  | <b>0.2</b> |
| <b>5. Эзэмшигчийн өмч</b>                                                                             |                          |                          |                           |                    |                  |            |
| Өмч:                                                                                                  | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| - төрийн                                                                                              | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| - хувийн                                                                                              | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| - хувьцаат                                                                                            | 102,370,300.00           | 102,370,300.00           | -                         |                    |                  | -          |
| Халаасны хувьцаа                                                                                      | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Нэмж төлөгдсөн капитал                                                                                | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл                                                                   | 23,340,772,000.00        | 23,340,772,000.00        | -                         |                    |                  | -          |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц                                                                     | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг                                                                        | -                        | -                        | -                         |                    |                  | -          |
| Хуримтлагдсан ашиг                                                                                    | 56,469,151,946.31        | 65,154,974,303.81        | 8,685,822,357.50          |                    |                  | 0.6        |

|                                |                    |                    |                  |     |
|--------------------------------|--------------------|--------------------|------------------|-----|
| Эзэмшигчийн өмчийн дүн         | 79,912,294,246.31  | 88,598,116,603.81  | 7,007,195,289.51 | 0.8 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 107,002,276,282.37 | 114,009,471,571.88 | 8,685,822,357.50 | 1.0 |

Төлбөрийн чадварын харьцаа

|                                 |                   |                   |                    |
|---------------------------------|-------------------|-------------------|--------------------|
| Эргэлтийн харьцаа               | 2.44              | 2.88              | 0.44               |
| Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа | 0.79              | 0.58              | -0.21              |
| Ажлын капитал                   | 55,547,289,352.06 | 47,759,306,393.11 | (7,787,982,958.95) |
| Мөнгөн эргэлтийн харьцаа        | 2.32              | 2.35              | 0.03               |

Өрийн харьцаа

|                             |      |      |       |
|-----------------------------|------|------|-------|
| Өрийн харьцаа               | 0.25 | 0.22 | -0.03 |
| Өр төлбөр ба өмчийн харьцаа | 0.34 | 0.29 | -0.05 |
| Хүү нөхөх чадвар            |      |      |       |
| Дайчлагдсан капитал         | 0.45 | 0.33 |       |

Хөрөнгийн ашигт ажиллагааны харьцаа

|                          |       |       |       |
|--------------------------|-------|-------|-------|
| Нийт хөрөнгийн ачаалал   | 1.20  | 0.98  | -0.22 |
| Үндсэн хөрөнгийн ачаалал | 1.83  | 1.73  | -0.10 |
| Бараа материалын эргэц   | 6.85  | 3.96  | -2.89 |
| Авлагын эргэц            | 19.22 | 11.74 | -7.49 |

Ашигт ажиллагааны харьцаа

|                          |      |      |       |
|--------------------------|------|------|-------|
| Нийт ахуйц ашиг          | 0.08 | 0.09 | 0.02  |
| Борлуулалтын өгөөж       | 0.07 | 0.08 | 0.01  |
| Хөрөнгийн өгөөж          | 0.08 | 0.08 | 0.00  |
| Эзэмшигчийн өмчийн өгөөж | 0.11 | 0.10 | -0.01 |

АУДИТОР



Д.ЧУЛУУНБАТ